



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/36

Дуурсах

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.21 дэх заалт, Ахмад настны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дах заалт, Эрүүл мэндийн сайдын А/780 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Жил бүр уламжлал болгон зохион байгуулладаг “Нарны алхалт” дасгал хөдөлгөөний үйл ажиллагааг 2022 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. Үйл ажиллагааг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Олон нийтийг идэвхтэй хөдөлгөөнд уриалж, дархлаагаа дэмжин дасгал хөдөлгөөнөөр хичээллэх сонирхол, санаачилгыг нэмэгдүүлэх, тэднийг хөдөлгөөний дутагдал, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн, нарны алхалт үйл ажиллагааг зохион байгуулан ажиллахыг ахмад настан, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Ц.Амарсайнуу)-д үүрэг болгосугай.


4. Үйл ажиллагаанд зарцуулах 870.000 (Найман зуун далан мянган төгрөг)-ийг төсөл хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Ахлан нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д даалгасугай.

ДАРГА  Н.ЭНХЖАРГАЛ



Эрүүл мэндийн газрын даргын оны
..... дугаар сарын ны өдрийн
N36 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



УДИРДАМЖ

“Нарны алхалт” дасгал хөдөлгөөний үйл ажиллагаа
зохион байгуулах тухай

НЭГ. Үндэслэл:

Дэлхийд хүн амын нас баралтын 6% нь хөдөлгөөний хомсдолоос хамааралтай байна. Хөдөлгөөний идэвхгүй байдал нь зүрх судасны өвчин, чихрийн шижин, хавдар, таргалалт зэрэг халдварт бус өвчнийг нэмэгдүүлж жилд дунджаар 3.2 сая хүн хөдөлгөөний дутагдлаас үүдэлтэй өвчлөлөөр нас барж байна.

Монгол улсын 15-69 насны хүн амын 21.9% нь хөдөлгөөний хомсдолтой, 52.4% нь ажлын байрандаа, 48.2% нь амралт чөлөөт цагаараа идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй гэдгийг ХБӨ, осол гэмтлийн шалтгаан эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг тогтоох үндэсний 4-р судалгаанд дурджээ.

Зонхилон тохиолдож буй эдгээр өвчлөл, нас баралтад нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийн түгээмэл тохиолдох нь зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи тамхины хэрэглээ бөгөөд таргалах, цусны даралт ихсэх, цусан дахь өөх тос, сахарын хэмжээ нэмэгдэх байдлаар өвчлөл нас баралтад хүргэх шалтгаан болж байна.

Иймд хүн амын нас, биеийн онцлогт тохирсон идэвхтэй хөдөлгөөн хийхэд дэмжлэг үзүүлэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх иргэдийн тоог нэмэгдүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.

ХОЁР. Зорилго:

Настныг алхалт, идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллүүлэх замаар эрүүл мэндээ хамгаалах, зөв дадал хэвшил, зан үйлийг төлөвшүүлэх тэдний амьдралын чанарыг дээшлүүлэх

ГУРАВ. Зорилт :

1. Идэвхтэй дасгал хөдөлгөөнд иргэдийг татан оролцуулах, алхалтыг бүх нийтийн хүртээл болгох,

2. Дасгал хөдөлгөөнөөр хичээллэх сонирхол, санаачилгыг нэмэгдүүлэх

ДӨРӨВ. Зохион байгуулах арга хэмжээ:

1. Алхалт
2. Эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн

ТАВ. Үр дүн:

1. Дасгал хөдөлгөөнөөр эрүүл мэндээ хамгаалах, алхагчдын клубд хамрагдах иргэдийн тоо нэмэгдэнэ.
2. Алхалтаар эрүүл мэндээ хамгаалах, сурталчилах, дэлгэрүүлэхэд дэмжлэг болсон байна.


ЗУРГАА. Зохион байгуулах хугацаа:

2022 оны 05 дугаар сарын 21-нд Баганат талбайгаас Оготонтой булаг хүрээд ирэх, /Долоо хоног бүрийн хагас сайн өдөр өглөө 08:00 цагаас, 10:00 цагийн хооронд/

ДОЛОО. Хамрах хүрээ

Баянхонгор сумын Төрийн болон Төрийн бус байгууллагууд, ард иргэд

Эрүүл мэндийн газрын даргын *М.Э.Э* оны
.....05..... дугаар сарын ..10..... ны өдрийн
N36 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Шаардагдах зардлын тооцоо

Д/д	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ ₮	Нийт үнэ ₮
1	2	3	4	5	6
1	Хулдаасан хэвлэл	3*4	1	18 000	120 000
2	Чанга яригч спикер	ш	1	750 000	750 000
Нийт					870.000

-----o0o-----